

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын
2023 оны 06 дугаар сарын мэдээ

2023.06.25

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр: “Эх үрсийн баяр” 6-р сарын 01 ны өдөр олон хүүхэд төрүүлж өсгөн улс эх орныхоо хөгжил цэцэглэлтийн төлөө хөдөлмөрлөж байсан өндөр настан эрхэм ээжүүдийг “Буянтай ээж”, “Ачлалт ээж”, “Энэрэлт ээж”-ээр өргөмжлөн алдаршуулах хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулсан. Мөн ажилчин албан хаагчдын хүүхдүүдэд гарын бэлэг гардуулан ажиллаа.

Эх үрсийн баяр буюу 06 сарын 01-нд ИТХ ГХУСАЗСЗ-тэй хамтран “Авто машингүй” “Архигүй өдөр” өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлээ.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, ШШГА, хүний эрхийн комисс хамтран 06 сарын 06 ны өдөр Баяндэлгэр сумын салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч төрийн алба хаагчид, иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр болон хүний эрхийн чиглэлээр сургалт зохион байгууллаа.

б/ **Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:** Тухайн сард дээд газраас 28 албан бичиг ирсний 8 нь хариутай, хугацаа болоогүй-2, хугацаа хоцорсон албан бичиг байхгүй болно.

Баруун -Урт хотод зохион байгуулагдсан хөрөнгө оруулалт хөгжлийн чуулганд оролцож сумын видео танилцуулга болон нугалбар хөрөнгө оруулалт хийх төслийг танилцуулсан.

Сумын засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 29 -ны өдрийн А/92 тоот захирамжаар 2023 оны хагас жилийн малын түүвэр судалгааг 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсан.

Хоёр: **Төсөв санхүүгийн чиглэлээр:** 2023 оны орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ Шилэн дансанд тухай бүр болон сар, улирлаар тавигдах мэдээллийг бүрэн тавьж илгээлээ.

Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэг , Тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилтыг хуваарийн дагуу эхний 4 сар бүрэн олгогдсон.

Байгууллагын өр авлага ,төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч ЗГУСХС бүрэн мэдээлсэн .

Статистикийн байгууллагад хүргүүлэх сар улирлын мэдээ тайланг хугацаанд нь гаргаж явуулсан.

Төсөвт байгууллауудын цалин болон бусад гүйлгээг төлбөрийн хүсэлтийн дагуу цаг хугацаанд нь санхүүгийн программд шивж гүйцэтгэн төлбөрийн хүсэлт болон баримтыг хуулгатай тулган архивын нэгж үүсгэн ажиллаа.

Төсөвт байгуулага, татварын орлогын дансанд гарын үсгийн баталгааг авч нотиаротоор баталгааж, цахим мэдээллийн системд оруулж ажиллаа.

ОНХСан , малын тоо толгойн албан татвараар хийгдэх ажил болон засаг даргын мөрийн хөтөлбөрөөр хийгдсэн ажлуудын санхүүжилт хуваарын дагуу олгогдож цаг хугацаандаа хийгдсэн.

Төсвийн газруудын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан хугацаанд нь e-balance программд шивж сумын нэгдсэн тайлан гаргаж аймгийн санхүү төрийн сангийн хэлтэстэй тооцоо нийлж , аудитын газар хүргүүлж шалгуулсан.

Гүйлгээний баримтыг сар бүр архивлан үдсэн. Шилэн дансны мэдээлийг шивж оруулсан ,

ОНХС-ын хийгдсэн ажлын төлөвлөгөө,ажлын хэсгийн жагсаалтыг программ-д шивж оруулсан.

Гурав. **Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:** Бага насны хүүхдийг зам тээврийн осол хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Хууль зүйн хэлтэс, цагдаагийн газрын хамтарсан мэдээлэл сургалтанд цахимаар хамрагдаж хууль зүйн хэлтсээс бэлтгэн ирүүлсэн анхааруулга зурагт хуудсыг, сумын цагдаагийн тасагтай хамтран айл өрхт танилцуулан, гаднаа зориулалтын машины зогсоолтой болох талаар мэдээлэл өгч ажилласан.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Эрүүл мэндийн төв: Нийт үзлэгт- 809 урьдчилан сэргийлэх үзлэг – 558 иргэн хамрагдлаа. Больницод хэвтэн эмчлүүлсэн нийт – 31 үйлчлүүлэгчээс 0-5 насны 3 хүүхэд тусламж үйлчилгээ авсан. Алсын дуудлага – 13 ирсэн дуудлага бүрийг хугацаа алдалгүй шийдвэрлэсэн.

Жирэмсний хяналтанд нийт 9 эх орсноос эрт хяналт- 9 .АНЭ-т төрсөн- 16, Суманд төрсөн- 0, Эх хүүхдийн эргэлт – 15, Эсийн шинжилгээ – 44, Хөхний үзлэгт – 170. СЗЭ-ний кабинетаар нийт 44 үйлчлүүлэгч тусламж үйлчилгээ авсан.

Ерөнхий боловсролын сургууль: 5,9 дүгээр ангийн сурагчдын “Би дэвшлээ”, дотуур байрын сурагчдын “Тайлант өдөрлөг” 12 дугаар ангийн сурагчдийн “Эрдмийн баяр” тус тус амжилттай зохион байгуулагдлаа.

06 сарын 01-ны өдөр “Нарны хаан” хүүхдийн фестивалыг зохион байгуулж дугуйлан, секцэд хамрагдсан сурагчид өөрсдийн тайланг тавьлаа.

Аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас “ Хүүхэд хөгжил , хамгааллыг дэмжих жилийн хүрээнд “Нэгдүгээр -Хүүхэд” аялах, туг дэвтэр 05 сарын 29-ны өдрөөс 06 сарын 02-ны өдөр хүртэл 7 хоног аяллаа.

Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан улсын аварга шалгаруулах өсвөр үеийн жудо бөхийн тэмцээнд аймаг орон нутгаа төлөөлөн багш Б.Даваажаргал, Сүх-Очир дасгалжуулагчтай тамирчид оролцлоо. Уг тэмцээнээс 2 сурагч хүрэл медаль хүртсэн.

Цахим ангийн хэрэглээг нэмэгдүүлж, онлайн хичээлийн чанарыг сайжруулах үүднээс MindTech хэрэглэгч сургуулиудын дунд физикийн хичээлийн онлайн давтлагат 20 сурагч амжилттай хамрагдлаа. Уг давтлаганд II байранд шалгаран 3D програмын эрхийг авлаа. 12а ангийн сурагч Бадамраахай II байранд шалгаран таблетны эзэн боллоо.

06 сарын 15-19-ны өдрүүдэд ЭНШ зохиогдож 12 дугаар ангийн 50 сурагч амжилттай хамрагдлаа.

ЭЕШ-д 529.9%-тай шалгагдан 2023 оны сургуулийн менежментийн зорилтоо давуулан биелүүлсэн.

Цэцэрлэг: Сурагчдын зуны амралт эхэлж, анги танхимын тоглоом, эд хогшлыг цэгцэлж, гэр ангиудыг буулгаж агуулахад хийсэн.

Гадаа талбайн зүлэг, цэцгийн мандлын хөрсийг сийрүүлж услан мандлын цэцгийн үрийг суулгасан. Туслах багш нар хавар нарын ногооны үрсэлгээ хийсэн. Үүнийгээ хүлэмжинд суулгасан.

Захиргаа аж ахуйн ажилчид өдөр бүр цагийн хуваарын дагуу гадна талбайн зүлэг, цэцгийн мандал, хүлэмжний ногоо, мөн ногоон байгууламжинд тарьсан мод услах зэрэг аж ахуйн ажлуудыг хийж байна.

6 сарын 8-9 ны өдрүүдэд БШУГ-аас зохион байгуулсан “Удирдах ажилтны зөвлөгөөн”-д багш М.Дэлгэрбуян оролцож 2022-2023 оны хичээлийн жилд хийж хэрэгжүүлсэн онцлог ажлууд, хөрөнгө оруулалт зэрэг үйл ажиллагааны тайланг тавьсан.

Мөн 6 сарын 15 нд багш Б.Бибиш Хүүхэд хамгааллын багийг эрчимжүүлэх сургагч багш нарын сургалтанд оролцлоо.

Хувилбарт сургалтын багш Ш.Эрдэнэбаяр 6 сарын 19-21 ны хооронд “Таблеттэй багш” хөтөлбөрт хамрагдан батламж, таблетаа гардаж авсан.

Соёл: Соёл урлагийн 11 үйл ажиллагаа зохион байгуулагдаж 2947 иргэд хамрагдлаа. Улсын баяр наадмын комисс хуралдаж наадмын бэлтгэл ажилд орох үүрэг чиглэл өгөв. 2023 оныг Хүүхэд хамгааллын жил болгосонтой холбогдуулан Соёлын төвийн хамт олон хүүхдүүддээ ажлын онцлогоо танилцуулахын зэрэгцээ сумын онцлог дурсгалт газруудаар аялуулж “Хүүхэдээ сонсоё” өдөрлөг зохион байгуулж байгууллагын ажилчдын 17 хүүхдэд 340.000 төг.ний витаминжуулалт хийлээ.

Номын сан нь 2023 оны 6-р сард ажлын 8 цагаар тогтмол ажиллаж уншигч үйлчлүүлэгчдэд гэрээр болон танхимаар ном олгож ажиллаа.

Байнгын уншигч 25, ирэгсэд 168 хүнд 196 ном гэрээр олгож 9 хүнд утсаар болон амаар лавлагаа өгч 5 татгалзал бүртгэлээ.

Соёлын сэргэлт 2023 аяны нээлтэнд шинэ, хүүхдийн, ховор номын үзэсгэлэн гаргалаа.

Номын сангийн автоматжуулалтын Lib4Упрограммд фондын номыг оруулах уншигчийг бүртгэх ажлыг хийж байна.

Байгууллагын эцэг эхийн зөвлөлтэй хамтран байгууллагын ажилчдын хүүхдүүдэд сум орныхоо түүх соёлын дурсгалуудыг танилцуулах номтой аялал зохиолоо. Хүүхдүүдэд тухайн дурсгалын талаар тайлбарлан таниулж тэдгээр дурсгалын тухай номоос уншиж өгч уншуулж үзсэн дурсгалуудыг нь зуруулах зэрэг өртөөчилсөн ажлуудыг зохион байгууллаа.

Соёлын сэргэлт 2023 аяны нээлтэнд Соёлын биет бус өв тээгч Б.Өлзийтогтохын суран эдлэл Г.Оюунцэцэгийн монгол дээл , цамц Я.Оюун- Эрдэнийн дээсэн эдлэл Ж.Наранцэцэгийн гараар нэхсэн хөшиг дэрний уут зэрэг 58 бүтээлээр үзэсгэлэн гаргаж 154 хүн үзэж сонирхлоо. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн нээлтэнд цахилгаан хөгжим, дууны дугуйлангийн сурагчидын “Хүүхэд нас” тоглолт болж үзэгч хүүхэд багачуудаас азтай 4 хүүхэд шалгарууллаа.

Эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран “Одонтой ээжүүд ” арга хэмжээ баярын хурал ЗДТГ-тай хамтран Алдарт эх одон „Дархан бэр гардуулах ёслол ” ИТХ-тай хамтран Эхчүүд алдаршуулах ёслолын арга хэмжээнүүдийг зохион байгуулж Ижийдээ дуулъя тоглотыг нийт ард иргэд ээжүүддээ өргөн барьлаа.

Соёлын сэргэлт 2023 аяны нээлтэнд Соёлын төвийн дэргэдэх зургийн дугуйлангийн хүүхдүүдийн үзэсгэлэн ХЗТ-ын уран бүтээлчид ардын авъяастнуудын урлагийн тоглолт, ард иргэдийн дунд АХА тэмцээн үдшийн цэнгүүн болсон.

ҮЛГЭРЧ СҮХБААТАРЧУУД соёлын боловсролын хөтөлбөрийн хүрээнд Үлгэрийн цаг хөтөлбөрт АБТА Г.Төмөрхуяг багш оролцож Дарьганга ардын үлгэр “Сайн түшмэд” үлгэрийг хүүхэд багачуудад ярьж өгч дарьганга үг хэллэгийг тайлбарлан үлгэрийн үйл явдалын тухай тэмдэглэл хөтлөх, зураг зурах даалгавар өгсөн. Үлгэрийн цагт нийт 15

хүүхэд хамрагдлаа.Тухайн үлгэрийг Соёлын төвийн Facebook хуудсанд байршуулж тавьсан.

Ширээт багийн С.Соёл- Эрдэнийн элэг шилжүүлэн суулгах эмчилгээнд зориулж сумын залуучуудын холбоотой хамтран “Баярлалаа” тоглолт үдшийн цэнгүүнийг зохион байгуулж орлогыг 100 хувь гардуулж өгөв.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчны чиглэлээр: Аймгийн БОАЖГ-аас зохион байгуулсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг хангах, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг зориулалтын дагуу зарцуулах тухай сургалтад орлогч дарга, санхүү албаны дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарын бүрэлдэхүүнтэй хамрагдлаа. 2024 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогийг зарцуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг байгаль орчны мэдээллийн цахим санд нийтэллээ.

Нэгдсэн хогийн цэгийн талбайд үүссэн хогний овоолгийг булшлах цэг рүү хийх ажлыг 04 дүгээр сараас эхлэн гүйцэтгэж энэ сард цэгцэлж дууслаа. Иргэд, олон нийтийн буруутай үйл ажиллагаа, ухамсаргүй байдлаас болон өмнөх жилийн хийсэн ажлын үр дүн буурч байгааг бууруулах зорилгоор зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ авч ажиллаж байна.

“Бүх нийтээр мод тарих” үндэсний өдрөөр сумын хэмжээнд бүх нийтээрээ мод тарих үйл ажиллагааг зохион байгууллаа.

Сумын “Хөдөлмөрийн баатруудын” цэцэрлэгт хүрээлэнгийн 23 га газарт төрийн болон төрийн бус 20 байгууллагын 320 гаруй алба хаагч, ажилчид 5 мянган мод тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүллээ. Тарьсан модны усалгаа, арчилгааг ЗДТГ-н байгаль орчны тасаг хариуцан ажиллаж байна. Мөн 128 өрхийн 320 гаруй иргэд эзэмшлийн хашаандаа нийт 1.5 мянган мод тарьсан байна.

Хагас жилийн байдлаар нийт 6400 хайлаас, 100 улиас модыг тарьж ажилласан тухай тайлан мэдээг аймгийн БОАЖГ-т хүргүүлээд байна. Бүх нийтээр мод тарих ажлын зардалд нийт 25 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Хагас жилийн малын тоо тооллогын түүвэр судалгаанд 206 өрх сонгогдож 2023 оны 05 дугаар сарын 30- наас 06 дугаар сарын 06 ныг хүртэл зохион байгуулж, нэгтгэлийг 06 дугаар сарын 15 нд статистикийн хэлтэст хүргүүлж багуудын ХАА-1, ХАА-2 мэдээг өрхөөр гаргаж тулгалтыг хийж байна.

2023 оны 05 дугаар сарын 19-20 ны шороонд шуурганд хорогдсон 82 өрхийн 4905 толгой мал, мөн нийт малын 50 – аас дээш хувь нь хорогдсон 18 өрхийн малыг нэгтгэж ХХААГазарт хүргүүлсэн.

Долоо хоног бүрийн 3 дахь өдөр малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн цахим системд том малын хорогдол, мал төллөлт, бойжилтын мэдээг шивж оруулдаг.

Хагас жилийн байдлаар нийт хээлтэгчийн 53,32 буюу 130534 толгой мал төллөсөн. Үүнд: ингэ – 153, гүү -3575, үнээ -5161, эм хонь – 79364, ямаа – 4228. Үүнээс төлийн хорогдол нийт 28648 байна. Үүнд: ботго – 2, унага – 220, тугал – 294, хурга – 17854, ишиг – 10278.

Том малын зүй бус хорогдол нийт малын 10,32% буюу нийт 58371 толгой мал хорогдсон. Үүнд: тэмээ- 2, адуу - 2481, үхэр- 3410, хонь - 28904, ямаа- 23574 үүнээс хорогдсон хээлтүүлэгч азарга – 73, бух – 68, хуц – 351, ухна -412 байна.

Бэлчээр хамгаалах ажлын хүрээнд оготно устгалын ажлыг 1873 га бэлчээрийн талбайд хийж гүйцэтгэлээ. Үүнд: Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2 тн бактерийн бэлдмэл “ШИМ” ХХК – аас худалдан авч 998 га талбайд, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,75 тн бактерийн бэлдмэлийг 875 га бэлчээрийн талбайд оготно устгалын ажлыг хийж гүйцэтгэлээ. Уг ажлыг чанартай зохион байгуулах, хянах, үр дүнг тооцох үүрэгтэй сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсгийг байгуулсан.

Тухайн арга хэмжээнд Баян баг 298 га, Дэлгэр баг 368 га, Төв баг 507 га, Дөхөм баг 385 га, Хонгор баг 175 га, Ширээт баг 140 га бэлчээрийн талбайд тэмцсэн.

Тухайн ажлын гүйцэтгэлд малчин өрх 40, 10 мотоцикль, 2 автомашиныг дайчлан тээвэр шатахууны зардалд 700,0 мянган төгрөг, бактерийн бэлдмэлд 13,000,000 төгрөг зарцуулсан.

Нэгтгэсэн: ХЭЗХ-мэргэжилтэн

Ж.Долгорсүрэн